



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/138

Булган сум

### Төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого", Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь заалт, 2022 оны 04 дүгээр сарын 29-ний Төрийн хэмнэлтийн тухай хууль, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны II/04, XIII/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүр аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн төсвийн төсөлд тусган, гадаад дотоодын төсөл хөтөлбөр, хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэн, хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт), сумын Засаг дарга, агентлаг, байгууллагын удирдлагуудад тус тус даалгасугай.

3.Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнгийн талаарх мэдээллийг хагас жил тутамд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд танилцуулж байхыг Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн А/135 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



2023 оны 03 сарын 15 өдөр /Булган сум /2023/Захирамж

8323010263